

Өнөө үед Ази, Африк, Латин Америкийн нийтдээ 220 сая гаруй хүн ам, 12 сая гаруй хавтгай дөрвөлжин км газар нутагтай Афганистан, Алжир, Ангол, Мозамбик, Этиоп, Никарагуа зэрэг 20 гаруй улс орон социалист чиг баримжааны замаар замнаж байна. Наяад онд эдгээр орны хөгжлийн цар хүрээ өргөжин, дэлхийн тавцанд гүйцэтгэх үүрэг нь ч улам өсөн нэмэгдэв. ЗХУКН-ын XXVII их хурал дээр нөхөр М. С. Горбачевын тавьсан улс төрийн илтгэлд онцлон тэмдэглэхдээ: «Хүн төрөлхтний олонхи болсон улс түмний амьдралд нийгэм эдийн засгийн өөрчлөлтийн алгуур, хэцүү боловч зогсолтгүй процесс үргэлжилж байна»<sup>1</sup> гэсэн билээ. Тийм улс түмэнд чөлөөлөгдсөн орнууд, түүний дотроос социалист чиг баримжааны орнуудын ард түмэн зүй ёсоор орох билээ.

Шинэ нийгмийн үндсийг тавих өөрчлөн байгуулалт нь дотоод гадаадын дайсагнагч хүчний эсэргүүцэлтэй тулгарч, үлэмж бэрхшээл туулж байгаа ч гэсэн социалист чиг баримжаат орнууд сонгож авсан замаараа итгэл төгс урагшилж, капиталист биш хөгжлийн онол практикийг олон шинэ зүйлээр баяжуулж байгаа юм.

Шинжлэх ухааны социализмыг үйл ажиллагааныхаа онолын үндэс болгосон хөдөлмөрчдийн манлай нам төлөвшин бий болох нь социалист чиг баримжааны маш чухал хүчин зүйл мөн. Үүийг Конго, Ангол, Мозамбик, Бенин, Этиоп зэрэг орны туршлага харуулж байна.

Хөдөлмөрчдийн манлай нам зохион байгуулалтын хувьд тухайн орны түүхэн тодорхой нөхцөл байдлаас шалтгаалж харилцан адилгүй замаар үүсэн байгуулагджээ. Ангол, Мозамбик зэрэг зарим оронд манлай нам үндсээ чөлөөлөх хувьсгалт байгууллага (фронт)-ын үндэс суурь дээр бий болж байхад Конго, Бенин, Этиоп зэрэг хэсэг оронд чанарын хувьд цоо шинэ улс төрийн байгууллага болон үүсчээ.

Хөдөлмөрчдийн манлай нам ийнхүү төлөвшин бий болсон нь чөлөөлөгдсөн орнууд дахь хувьсгалт процессын хөгжлийн үйл явцад объектив, субъектив урьдчилсан нөхцөл бүрэлдсэний үр дүн бөгөөд энэ нь үндэсний ардчилсан хувьсгалын гүнзгийрэл, ардын ардчилсан хөгжмийн хандлагыг тусгаж байна. Хөдөлмөрчдийн манлай намын программын баримт бичигт ажилчин анги, тариачдыг улс төрийн манлайлагч, хөдөлмөрчдийн хамгийн зохион байгуулалттай отряд мөнийг зааж байна.<sup>2</sup>

Түүнчлэн сүүлийн жилүүдэд хувьсгалт ардчилсан намуудаас баталсан программын баримт бичигт шинэ нийгэм байгуулахад шилжилтийн тодорхой үе шат чухал болохыг харгалзан үзэх болжээ. Тухайлбал, Этиопын нам программдаа «Марксизм-ленинизмыг удирдлага болгон социалист чиг баримжааг баримтлан ардчилсан хувьсгалын зорилтыг хэрэгжүүлнэ»<sup>3</sup> гэж заажээ.

<sup>1</sup> «Үнэн» 1986.11.26.

<sup>2</sup> Социалистическая ориентация освободившихся стран М., 1982. 12—129. В. Ф. Вольянский. Некапиталистический путь развития (на опыте африканских стран) М., 1983, 101—113.

<sup>3</sup> «Проблемы мира и социализма», 1978, No 1, с. 40.

Конгийн хөдөлмөрийн намын баримт бичигт «Конгын хувьсгал үндэсний ардчилсан шатандаа ороод байна. Цаашдын дэвшлийг хангах нөхцлийг энэ үед бүрдүүлэх болно»<sup>4</sup> гэжээ.

Афганистан, Ангол, Мозамбик зэрэг социалист чиг баримжаат орных манлай намуудын программын баримт бичигт ч мөн ийм зорилт тавьжээ.

Социалист чиг баримжаат орнуудын өнөөгийн хөгжлийн бас нэг чухал онцлог нь бодит социализмтай улам бүр ойртон нягтарч байгаа явдал юм.

Энэ нь нэгдүгээрт, социалист чиг баримжаат орнууд болон социалист хамтын нөхөрлөлийн орнуудын хоорондын харилцаа нь гэрээ хэлэлцээрээр хуульчлан бататгагдаж амжилттай хөгжиж байгаа; хоёрдугаарт, социалист нөхөрлөлийн орнуудын коммунист, ажилчны намууд, социалист чиг баримжаат орнуудын эрх баригч хувьсгалт намуудын хоорондын хэлхээ холбоо өргөжин гүнзгийрч, шинэ өндөр түвшинд гарч ирсэн; гуравдугаарт, социалист чиг баримжаат олон орон гадаад улс төрийн бодлого, үйл ажиллагаандаа интернационализмын зарчмыг улам бүр тууштай ба баримталж байгаагаар илэрч байна.

ЗХУКН-ын XXVII их хурлаас ЗХУКН-ын Төв Хорооны Улс төрийн илтгэлийн талаар гаргасан тогтоолд: «Дэлхийн хувьсгалт процессын хөгжил, өргөн олны ардчилсан болон дайныг эсэргүүцсэн хөдөлгөөий өрнөл энх тайван, саруул ухаан, сайн санааны асар их потенциалыг үлэмж өргөжүүлэн нэмэгдүүлж, энэ потенциал империализмын түрэмгий бодлогын эсрэг хүчирхэг хүч болж байна»<sup>5</sup> гэж цохон тэмдэглэсэн юм. Социалист чиг баримжаат орнууд уг потенциалыг бэхжүүлэхэд үлэмж хүчин чармайлт гаргаж ирлээ. Энэ орнууд тухайлвал НҮБ болон олон улсын бусад байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож тодорхой санал дэвшүүлэн мөн ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнууд, дэлхийн энхийг эрхэмлэгч хүчнээс халуун цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах чиглэлээр гаргасан удаа дараагийн амин чухал санаачлагуудыг халуунаар дэмжин, дэлхийн аль нэг бүс нутагт «халуун цэг» бий болгож байгаа АНУ, түүний хань хамсаатнуудын эсрэг шийдвэртэй тэмцэл явуулж байна.

Социалист чиг баримжаат орнуудад гарч байгаа нийгмийн чухал өөрчлөлтийн нэг бол тэнд ажилчин ангийн эгнээ өргөжиж, тэр нь үзэл суртал зохион байгуулалтын хувьд өсөн бэхжиж байгаа явдал юм. Түүнчлэн төрөөс хөдөө аж ахуйн талаар явуулж байгаа бодлогыг тариачин олон түмэн талархан хүлээн авч, улс төрийн амьдралд идэвхтэй оролцож байна.

Энэ бүх үйл явцтай уялдан социалист чиг баримжааны онол, арга зүйн зангилаа асуудлын нэг болсон түүний шалгуурыг улам тодорхой болгох асуудал зайлшгүй шаардагдаж байна.

**Энэ нь улс төрийн салбарт:** Тухайн орны бүх дэвшилт хүчний нэгдэл нягтралыг бэхжүүлж, төрийн удирдлагаас харгис элементүүдийг шахан зайлуулж улс төрийн талаар ганцаардуулах, нийгэм улс төрийн амьдралыг ардчилах, төрийн зүгээс үйлдвэрлэлийг удирдах хөдөлмөрчин олон түмнийг өргөнөөр татан оролцуулах энэ үндсэн дээр нийгэм-эдийн засгийн үндсэн өөрчлөлтийг хэрэгжүүлэх;

**Эдийн засгийн салбарт:** Тухайн орны эдийн засагт гадаадын капиталын ноёрхлыг эвдэн, капиталист өмчийн харилцааг устгаж, хөдөлмөрчин тариачдын ашиг сонирхолд нийцүүлэн хөдөө дэх үйлдвэрлэлийн

<sup>4</sup> Мөн тэнд 44-р тал.

<sup>5</sup> «Үнэн» 1986.III.7.

харилцааг өөрчилж, улс хоршооллын янз бүрийн хэлбэрийг хөгжүүлж, эдийн засгийн улсын салбар бий болгон бүх талаар хөгжүүлэх, хувийн капиталын үйл ажиллагааг хязгаарлах;

**Нийгмийн салбарт:** Нийгэм, улс төрийн амьдралд хөдөлмөрчин олныг татан оролцуулах, ажилчин ангийн эгнээг өсгөн, улс төрийн ухамсрыг нь дээшлүүлэх, ажилчин ангийн зүгээс нийт хөдөлмөрчдийг удирдахад бэлтгэх, хөдөлмөрчдийн аж байдлын түвшинг байнга дээшлүүлэх;

**Үзэл суртлын салбарт:** Хүн амын бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгаж, соёлыг бүх талаар хөгжүүлэх, хөрөнгөтний үзэл сурталтай шийдвэртэй тэмцэх, шинжлэх ухааны социализмын үзлийг дэлгэрүүлэх, пролетари ангийн үзэл суртлыг нийгмийн хөгжүүлэх материаллаг хүч болгон хувиргах зэрэг болно.<sup>6</sup>

Социалист чиг баримжаат орон гэдэг нь колонийн ба хараат байдлаас ангижирч, цаашдаа нийгмийн хөгжил дэвшил, түүхэн хэтийн төлөвийн хувьд капитализмд биш, харин социализмд аажимдаа шилжин орохоо илэрхийлж нийгэм эдийн засаг, улс төр, соёлын салбарт гүн гүнзгий дэвшилт өөрчлөлтийг хэрэгжүүлж буй улс орныг хэлж байна.

Одоо үед социалист чиг баримжаат орнуудын өмнө шийдвэрлэвэл зохих нийгмийн олон хурц асуудал тулгарч байгаа юм. Ийм нөхцөлд эдгээр орны хувьсгалт ардчилсан төр үйл ажиллагаандаа шинжлэх ухааны социализмыг хэр зэрэг хэрэгжүүлэхээс социалист чиг баримжааны хөгжлийн хувь заяа ихээхэн шалтгаалж байна. Социалист чиг баримжааны замаар хөгжих нь ангийн тэмцлийн нарийн түвэгтэй үйл явц юм. Нийгэм-эдийн засгийн бүтэц нь бүрэн гүйцэд төлөвшөөгүй, ажилчин ангийн байр суурь гүйцэд тогтворжиж чадаагүйн улмаас социалист чиг баримжааны замаас ухрах явдал ч гарч байв. Жишээлбэл Гана, Мали, Сомалийн туршлага үүнийг гэрчилнэ.

Социалист чиг баримжаат орнуудын зонхилох хэсэг нь колоничлолын уршгаар дорой хөгжсөн үйлдвэрлэх хүчин, нийгмийн харилцааг өвлөн авчээ. Аж үйлдвэр зөвхөн эхлэлтийн төдий байдалтай байна. Эдийн засгийн үндсэн салбарт феодал, хүй нэгдлийн газар эзэмшил, газар ашиглалт зонхилж байгаа юм.

Эдгээр оронд капиталист биш өөрчлөлт хийж байгаа нийгэм эдийн засгийн бааз нь олон хэвшилт эдийн засаг бөгөөд хэвшил бүр нь өөрийн бяцхан үйлдвэрлэх хүчин, үйлдвэрлэлийн харилцаанаас бүрэлдэн, тус тусын хөгжлийн өвөрмөц үедээ ороод байна. Энэхүү олон хэвшлийн гүйцэтгэж байгаа үүрэг, хэтийн төлөв нь харилцан адилгүй байгаа бөгөөд үүнээс шалтгаалан капиталист биш хөгжлийг хангах зорилго улс орны эдийн засгийн тусгаар тогтнолын эрх ашгийн үүднээс эдгээр хэвшил тус бүртэй харьцах чиглэл боловсрон гарч байна.<sup>7</sup>

Ихэнх тохиолдолд хөгжиж байгаа орнууд империалист колонийн ноёрхлын үед байсан эдийн засгийн хоцрогдсон бүтцийг өөрчлөхөд улсын секторт түшиглэж байгаа нь капиталист биш замын улс төр, эдийн засаг, үзэл суртлын нөхцлийг бүрдүүлж байна<sup>8</sup>. Социалист чиг баримжаат орнуудын эдийн засагт улсын секторын эзлэх хувь нэмэгдэж, үндэсний орлогын

<sup>6</sup> Социалистическая ориентация освободившихся стран. М., 1982. стр. 88–89. Г. Ф. Ким. От национального освобождения к социальному М., 1982, с. 153.

<sup>7</sup> Н. Дангаасүрэн, Гуравдахь ертөнц: Эдийн засгийн тусгаар тогтнолын асуудал. УБ., 1977. 39-р тал.

<sup>8</sup> Ц. Баатар Социалист чиг баримжаат орнууд дахь улсын секторын шинж төлөв «Дорнодахины судлалын асуудал» 1983, No 1, 58-р тал.

үйлдвэрлэлд түүний эзлэх хувийн жин 30—50 хувийн хооронд хэлбэлзэж байна.<sup>9</sup>

Социалист чиг баримжаат орнуудын нийгэм-эдийн засгийн өөрчлөн байгуулалтын нэг гол зүйл нь хөдөө дэх үйлдвэрлэлийн харилцааг өөрчлөх явдал юм. Эдгээр орнуудын үйлдвэрлэлийн хоршоолол бол үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дээшлүүлэх үр ашигтай хэлбэр болохоо харууллаа. Үйлдвэрлэлийн хоршооллыг хөгжүүлж, капиталист биш хөгжлийн нийгэм-эдийн засгийн үндсийг бэхжүүлэх нь газар тариалангийн шинэчлэлт, өөрчлөлтийг гүнзгийрүүлж, улс хоршооллын салбарын эдийн засгийн харилцааны төвшинг дээшлүүлж, улмаар хөдөлмөрч тариачид, ажилчин ангийн холбоог бэхжүүлэх чухал шижим юм.

Энэ бүхнээс үзэхэд социалист чиг баримжаат орнуудын төр ардчилсан өөрчлөлт хийхдээ юуны өмнө улс орныхоо эдийн засаг, соёлын хөгжлийн түвшин, нийгэм, ангийн бүтцийн онцлог, яс угсаа, шашин шүтлэг, өнгөрсөн түүх зэрэг тодорхой нөхцлүүдийг бүх талаар анхааран үзэж, түүний үндсэн дээр цаашдынхаа зорилтыг дэвшүүлэн тавихад чиглэж байна. Энэ чиглэл зөв болохыг бодит социализмын орнуудын туршлага давхар нотолж байгаа билээ.

БНМАУ-ын түүхэн туршлагаас үзэхэд капиталист биш хөгжлийн төлөө тэмцэлд улсын эдийн засгийн үүргийг өндөрт байлгаж, эдийн засгийн төрөл бүрийн системийг бий болгон дэмжиж, үндэсний эдийн засгийг хөгжүүлэх хэрэгт олон түмний ухамсартай оролцоог өргөжүүлэх явдалд онцгой анхаарал тавьж байсан юм. Энэ бол эдийн засгийн хувьд буурай хөгжилтэй орнуудад үндэсний биеэ даасан аж ахуй байгуулах эхлэлт мөн бөгөөд нөгөө талаар капитализмыг алгасан социализмд шилжих өнөөгийн хэв маяг хичнээн өвөрмөц онцлогтой байлаа ч гэсэн нийтлэг шинжтэй болох нь социалист чиг баримжаат орнуудын хөгжлийн туршлагаар давхар нотлогдож байна. Тийм ч учраас шинэ тулгар хөгжиж байгаа орнуудын нийгмийн дэвшилд тус дөхөм үзүүлэх зорилгоор улсын салбар, хоршооллын хөдөлгөөн, боловсон хүчний гүйцэтгэх үүрэг зэрэг олон чухал асуудлаар БНМАУ тогтоолын төсөл боловсруулан НҮБ, түүний салбар байгууллагын хурал чуулганаар нэг биш удаа хэлэлцүүлэн батлуулж түүнийг хэрэгжүүлэх талаар байнгын хүчин чармайлт тавьсаар ирсэн юм.

Социалист чиг баримжаат орнууд манай улсын капиталист биш хөгжлийн туршлагыг үлэмж сонирхож байгааг энэ орнуудын нам, төрийн удирдагчдын хэлсэн үг, бусад баримт бичгээс тодорхой харж болно. Тухайлбал, ААН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНААфГУ-ын Хувьсгалт Зөвлөлийн дарга Бабрак Кармаль «БНМАУ ын туршлага нь шинжлэх ухааны социализмын үзэл санааны үнэний шалгуур, хөгжлийн капиталист шат, үгээгүй хоосон байдал, гачаал зовлонгийн шатыг алгасан феодализм болон феодализмын өмнөх харилцаанаас социализмд шууд шилжихийн үлгэр дууриал болж»<sup>10</sup>, «үндэсний хөгжлийг шийдвэрлэх болон хөдөө аж ахуй, аж үйлдвэр зэрэг салбарт хуримтлуулсан Монгол Улсын баялаг туршлагыг бид өөрийн оронд шинэ нийгэм байгуулах явцад байнга авч хэрэглэж байна»<sup>11</sup> гэжээ.

<sup>9</sup> Государственный сектор и социально-экономический прогресс в развивающихся странах. К., 1980, с. 23.

<sup>10</sup> «Үнэн» 1983. 7. 13.

<sup>11</sup> «Үнэн» 1983. 7. 09.

МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж. Батмөнх «Социалист чиг баримжааг сонгож авсан улс орны өмнө тухайн үедээ манай орны шийдвэрлэж байсантай ойролцоо асуудал тулгарч байгааг тэдгээр орны нийгмийн хөгжлийн явц харуулж байна»<sup>12</sup> гэсэн билээ.

Нийгмийн хөгжил дэвшлийн түгээмэл зүй тогтол нь үндэсний өвөрмөц нөхцөлд өөр өөрөөр илэрдэг учраас алив туршлагад бүтээлчээр хандах шаардлагатай нь мэдээж хэрэг. Нийгэм эдийн засгийн ардчилсан өөрчлөлтийг хэрэгжүүлэхдээ улс орны хөгжлийн түвшин түүний дотоод бололцоо, тэр нь дэлхийн капиталист аж ахуйн системд болон олон улсын эдийн засгийн харилцаанд ямар байр суурь эзлэх зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэх явдал чухал юм. Үйлдвэрлэх хүчний хэт доогуур түвшинд нийгмийн зөрчлөлтийн асар өргөн программыг хэрэгжүүлэх нь зарим зөрчилд хүргэж болох учраас чанарын хувьд цоо шинэ үйлдвэрлэх хүчийг аажмаар тууштай бий болгож шинэ үйлдвэрлэлийн харилцааг бэхжүүлэх явдал хамгийн гол зүйл билээ.<sup>13</sup>

Түүнчлэн төрөөс улсын болон хувийн өмчийг зөв зохицуулан гадаадын капиталын үйл ажиллагааг хяналтандаа авч хөдөө аж ахуйн нийгмийн салбарын хөгжлийг бүх талаар бэхжүүлэхүйц нийгэм-эдийн засгийн хөгжлийн стратегийг боловсруулах нь цаашдын хөгжил дэвшилд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Өнөөгийн нөхцөл байдлаас шалтгаалан чөлөөлөгдсөн орнуудын бүх дэвшилт хүчнийг нэгтгэх, өөрөөр хэлбэл империализмын эсрэг эх оронч бүх хүчний төлөөлөгчдийг багтаасан үндэсний эх оронч фронт байгуулан хамтарч тэмцэх нь дээрхи зорилтыг хэрэгжүүлэхэд чухал хүчин зүйл болж өгнө.

Афганистан болон Африкийн социалист чиг баримжаат хэд хэдэн оронд чухамхүү тийм нэгдсэн фронт чухал үүрэг гүйцэтгэж байна.

Социалист чиг баримжаат орнуудад ангийн дайсагнасан хүчнүүд хувьсгалт засаг тогтсоны дараа ч шинэ сувгаар үүсч болно. Үүний уг сурвалж нь хотод хүнд суртлын зууч худалдааны хөрөнгөтөн, хөдөө тосгонд баян тариачид байгаа явдал юм. Чухамхүү хувьсгалын эхний шатанд тэдний эсрэг тууштай арга хэмжээ авахгүй бол эдийн засгийн улсын болон хоршооллын салбарыг өөрсдийн эрх ашигт үйлчлүүлэх аюултай байдаг юм. Социалист чиг баримжаат зарим оронд ч энэ байдал одоо ажиглагдаж байгааг судлаачид тэмдэглэж байна.

Социалист чиг баримжааг бэхжүүлэх өөр нэг чухал асуудал бол ажилчин анги, тариачдын хооронд нягт холбоо тогтоох явдал юм. Гагцхүү ингэснээр социалист чиг баримжаат орнууд цаашид социализм байгуулахад шаардлагатай материал техникийн болон нийгэм-улс төрийн угтвар нөхцөлийг бий болгож чадна.

Чөлөөлөгдсөн орнууд, түүний дотор социалист чиг баримжаат орнуудад өрнөж байгаа нийгмийн дэвшилт өөрчлөлтийг бэхжүүлэхэд ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад орноос үзүүлж байгаа зүйл бүрийн тусламж нь империалист хүчнээс үндэсний эдийн засагт нь онцгой түрэмгийлэл үйлдэж байгаа өнөө үед нэн чухал ач холбогдолтой хүчин зүйл юм.

ЗХУ социалист чиг баримжаат орнуудын нийгмийн амьдралын бараг бүх салбарт өгөөмөр тусламж үзүүлж байна. Энэ тусламж нь социалист

<sup>12</sup> «Үнэн» 1984.11.27.

<sup>13</sup> А. С. Григорьев. Научный социализм и современная революционная демо кратия Л. 1982, с. 65–66.

чиг баримжаат орнуудын өөрчлөн байгуулалтанд аятай таатай нөлөө үзүүлж, үйлдвэрлэлийг оновчтой бөгөөд үр ашигтай явуулах, түүний бүтцийг боловсронгуй болгоход чухал хувь нэмэр болж байна. Энэ талаар ЗСБНХУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Н. И. Рыжков, ЗХУКН-ын XXVII их хуралд тавьсан илтгэлдээ «Зөвлөлт Холбоот Улс Ази, Африк, Латин Америкийн орнуудтай хамтын ажиллагаагаа цаашид ч хөгжүүлэх болно. Бид эдгээр улсад тал бүрийн дэмжлэг үзүүлж байгаа нь үндэснийхээ эдийн засгийг төлөвшүүлж хөгжүүлэх, колонийн хор уршгийг гэтлэн давах, эдийн засаг, нийгмийн дэвшлийн замаар урагшлахад нь тус болж байна»<sup>14</sup> гэж онцлон тэмдэглэсэн билээ.

ЭЗХТЗ нь хөгжлийн капиталист биш замыг сонгон авсан оронтой олон талын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн, ЭЗХТЗ-ийн ажилтай танилцуулж, социалист хамтын нөхөрлөлтэй тогтоосон хэлхээ холбоог бэхжүүлэх зорилгоор сонирхогч орнуудаас ЭЗХТЗ-ийн үйл ажиллагаанд ажил хэрэгчээр оролцоход нь тус дөхөм үзүүлж байна. Энэ бүхэн нь шинэ нийгэм байгуулахад нэгэнт хуримтлагдсан туршлагыг ашиглан, орчин үеийн шинжлэх ухааны мэдлэг, шинэхэн техник технологийг өргөн эзэмшүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх талаар дэвшил хийх боломжийг социалист чиг баримжаат орнуудад олгож байна. Нөгөө талаар дээрх орнуудад үзүүлж байгаа тусламжийн хэмжээ ч жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Тухайлбал 80-аад оны эх гэхэд ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудаас хөгжиж байгаа орнуудад улсын салбараа бэхжүүлэх, байгалийн баялагаа ашиглах, үндэсний боловсон хүчин бэлтгэх явдлыг өргөтгөх үүднээс олгосон эдийн засаг техникийн тусламж, хөнгөлттэй зээлийн хэмжээ нийт дүнгээрээ барагцаалбал 42 миллиард рубльд хүрчээ.<sup>15</sup>

1984 оны зургадугаар сард Москвад болсон ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын дээд хэмжээний эдийн засгийн зөвлөлтөөний баримт бичигт «ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд эрх чөлөө, тусгаар тогтнолоо байлдан олсон улсуудад үндэснийхээ эдийн засгийг хөгжүүлэхэд нь эдийн засаг техникийн туслалцаа хойшид ч бололцооныхоо хэрээр үзүүлэх болно»<sup>16</sup> гэж заасан билээ.

Ийнхүү социалист чиг баримжаат орнууд ЗХУ болон социалист бусад орны тал бүрийн тусламж дэмжлэгт тулгуурлан сонгон авсан замаараа итгэл төгс урагшилж байна.

ЗХУКН-ын шинэчлэн боловсруулсан Программд «Эрх чөлөөгөө олсон олон орны сонгож авсан капиталист биш хөгжлийн зам, социалист чиг баримжааны зам нийгмийн дэвшлийн өргөн хэтийн төлөвийг нээж байна...Энэ бол түүхэн том ач холбогдол бүхий үзэгдэл мөн»<sup>17</sup> гэж тодорхойлсон билээ.

Капиталист биш замаар социализмд шилжсэн улс орнуудын түүхэн замнал болон социалист чиг баримжааны орчин үеийн практик нь шинжлэх ухааны коммунизмын онолд оруулж буй чухал хувь нэмэр, нийгмийн дэвшлийн дөт замын тухай марксист-ленинист сургаалын үнэн зөвийн яруу тод баталгаа мөн.

<sup>14</sup> «Үнэн» 1986.3.5.

<sup>15</sup> «Намын амьдрал» 1985. 7. 94-р тал

<sup>16</sup> «Правда» 1984.6.16.

<sup>17</sup> «Правда» 1986.6.16.